



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2019 оны 10 сарын 09 өдөр

Дугаар 80

Мандалговь

Хөрөнгө дахин үнэлж нээлттэй дуудлага  
худалдаагаар худалдах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2 дахь хэсгийн 77.2.3 дахь заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6 дугаар бүлгийн 6.2 дахь хэсгийн 6.2.1, 6.4 дахь хэсгийн 6.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Баянжаргалан сумын Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 17,000,000 /арван долоон сая/ төгрөгийн балансын үнэтэй, 239,583 /хоёр зуун гучин есөн мянга таван зуун наян гурав / төгрөгийн үлдэгдэл өртөгтэй 49-21 ДУА улсын дугаартай Форестер маркын автомашин, Дэрэн сумын Засаг даргын тамгын газрын 20,000,000 /хорин сая/ төгрөгийн балансын үнэтэй, үлдэгдэл өртөггүй 73-75 ДУА улсын дугаартай УАЗ-390942-018 маркын автомашины худалдах доод үнийг тус тус хавсралтын дагуу тогтоож нээлттэй дуудлага худалдаагаар худалдахыг зөвшөөрсүгэй.

Хоёр: Эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нээлттэй дуудлага худалдаагаар худалдаж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд бүрэн төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн газар /С.Ууганбаяр/-т үүрэг болгосугай.

Гурав: Эд хөрөнгийг худалдсаны дараа холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэхийг Баянжаргалан сумын Засаг даргын Тамгын газрын даргын түр орлон гүйцэтгэгч Э.Сувд, Дэрэн сумын Засаг даргын Тамгын газрын дарга Ц.Дуламсүрэнд тус тус даалгасугай.

Дөрөв: Энэхүү тогтоол гарсантай холбогдуулж Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 39 дүгээр

тоот тогтоол, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн 2019 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 61 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болгосугай.

Тав: Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /О.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

ДАРГА  ССҮХБААТАР



Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2019 оны 20 дүгээр сарын  
05 өдрийн 28 тогтоолын нэгдүгээр хавсралт



Дахин үнэлгээ тогтоож нээлттэй дуудлага худалдаагаар худалдах хөрөнгө

№	Сумын нэр	Байгууллагын нэр	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Дуудлага худалдааны үнэ
1	Баянжаргалан	ЗДТГ	49-21 ДУА Форестер автомашин	2012.07.19	17,000,000	16,760,417	239,583	1,750,000
2	Дэрэн	ЗДТГ	73-75 ДУА УАЗ- 390942-018 автомашин	2012.02.01	20,000,000	20,000,000	0	2,500,000
	Дүн				37,000,000 /гучин долоон сая/	36,760,417 /гучин зургаан сая долоон зуун жаран мянга дөрвөн зуун арван долоо/	239,583 /хоёр зуун гучин ес таван зуун наян гурав	4,250,000 /дөрвөн сая хоёр зуун тавин мянга/